



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/172/СТА-ТШЗ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2018 он



Аудитын код: САГ-2018/172/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn


Аудитор Ш.Отгонбаяр
Утас: 261740 Цахим хаяг: otgonbayarsh@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний Аудитын
Газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6

Од Бүртгэл Аудит ХХК
Захирал У.Оюунаа
Утас: 99051826 Цахим хаяг: oyunaa.u@odburtgel.mn

Аудитор: С.Буманцэцэг
Утас: 88067851 Цахим хаяг: bumantsetseg.s@odburtgel.mn

Улаанбаатар хот



Агуулга

Аудитын гэрчилгээ	
1. Аудитын тайлан	
1.1 Оршил	1
1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1-2
1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2-3
1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	3
1.5 Дотоод хяналт	3-4
1.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	4
1.7 Шилэн дансны мэдээлэл	4
1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
1.9.1 Үндсэн хөрөнгийн талаар	4-5
1.9.2 Цалингийн дансны талаар	5-6
1.9.3 Ээлжийн амралтын олговрын талаар	6
1.9.4 Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн талаар	6
1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал	6-7
1.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
1.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
1.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7-8
2. Менежментийн захидал	9
2.1 Цалингийн зардлын талаар	10-11
2.2 Үндсэн хөрөнгийн дансны элэгдлийн талаар	12
2.3 Ээлжийн амралтын олговрын талаар	13
2.4 Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн талаар	14
3. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16-17
3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	19-20
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21-23
3.6 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан	24



ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
ДАРГА Д.ОЮУНБИЛЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/504
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хүүхдийн төв номын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүүхдийн төв номын сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110.10.10.2018\Bichig_Khereg\Yawsan_Bichig_2018\02255A0104.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

070824

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.


Хүүхдийн төв номын сан нь санхүүгийн тайлант жилд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7, 26 дугаар зүйлийн 26.2 заалтууд, Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1, 49.6, Хүүхдийн төв номын сангийн хөдөлмөрийн дотоод журмын 9.5 заалтуудыг тус тус зөрчсөнөөс шалтгаалж цалин 24,331.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын зардал 2,647.6 мянган төгрөгөөр илүү тооцогдож, нийт 26,978.8 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
ДАРГА Д.ОЮУНБИЛЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/504
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хүүхдийн төв номын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.


Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүүхдийн төв номын сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherel\Yawsan_Bichig\2018\0223SAG104.Docx



1 Аудитын тайлан

1.1 Оршил

Хүүхдийн төв номын сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хүүхдийн төв номын сангийн дарга Д.Оюунбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгийн дансны элэгдлийг зөв тооцоолох, ажилчдын ажилласан цагийн нэгтгэл гаргаж баталгаажуулах, ээлжийн амралтыг зөв тооцоолох, ажил олгогчоос олгох хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн дүнгээс холбогдох татвар нийгмийн даатгалыг суутгахгүй байх, цалин хөлсийг сард хоёр ба түүнээс дээш удаа олгох, илүү гарсан цаг бүрт илүү цагийн хөлсийг тооцож байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.


1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газрын захиалгаар "Од бүртгэл аудит" ХХК аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүүхдийн төв номын сан төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан



төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дугаар сарын 23-наас 2018 оны 2 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг Од бүртгэл Аудит ХХК нь 2017 оны 2 дугаар сарын 23-нд ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын удирдлагад гардуулна.

2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Од бүртгэл Аудит ХХК-ийн С.Буманцэцэг ахлагчтай аудитын баг хэрэгжүүлэв.

Хүүхдийн төв номын сан нь 2017 оны төсвийн санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 31-нд Од бүртгэл Аудит ХХК-д хүргүүлсэн байна.

1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүүхдийн төв номын сан нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Хүүхдийн төв номын сангийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Дүрмээр хүлээсэн чиг үүргүүдтэй нэг бүрчлэн танилцав. Тус байгууллага чанарын өндөр түвшинд уран бүтээлээ туурвиж, ард түмнийг соён гэгээрүүлэх хөтөч нь байх эрхэм зорилготой байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т “Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна” 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн” гэж заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн 2017 оны төсвийн үйл ажиллагааны санхүүжилтийн эрхийг нээн төсвийн хуваарийг баримтлан БСШУСЯ-ны Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Хүүхдийн төв номын сан нь Мэдээллийг түгээж, Мэдлэгийг цогцлоох зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

1. Нийтэд үйлчлэх 6 танхим, хүүхэд залуучуудад үйлчлэх 1 зөөврийн номын сангаар дамжуулан:
 - Уншлагын танхимын үйлчилгээ

- Гэрээр ном олгох үйлчилгээ
- Зөөврийн номын сангийн үйлчилгээ
- Цахим номын сангийн үйлчилгээ
- Соёл, олон нийтийн ажил
- Лавлагаа, мэдээллийн үйлчилгээ
- Ерөнхий боловсролын сургуулийн номын санчдад сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг тус тус үзүүлж байна.

2. Ерөнхий удирдлага, арга зүйн хүрээнд:

- Хүүхдийн төв номын сангийн сан хөмрөгийг шинэчлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах;
- Хүүхдийн төв номын сангийн үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, шинэчлэл хийх;
- Хүүхдийн ном, хэвлэлийн архивын болон мэдээллийн сан бүрдүүлэх;

Хүүхдийн төв номын сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хүүхдийн төв номын сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/


Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хүүхдийн төв номын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Хүүхдийн төв номын сан нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ



нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хүүхдийн төв номын сангийн байгууллагын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт дунд байна.

1.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хүүхдийн төв номын сангийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс 488,557.5 мянган төгрөг, ЭМД-ын сангаас 439.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 7,592.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 15,695.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,039.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнээс урсгал зардалд 525,286.2 мянган төгрөг батлагдсанаас 522,538.9 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвөөс 2,747.2 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

1.7 Шилэн дансны мэдээлэл

Хүүхдийн төв номын сан нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас www.mcccl.mn сайтад шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан.

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт 6 дансанд нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

1.9.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тус төвийн 2017 оны үндсэн хөрөнгийн бүртгэлд 1 жилээс бага ашиглах хугацаа үлдсэн үндсэн хөрөнгүүдийн тайлант онд хамаарах элэгдлийн зардлыг 2,038.7 мянган төгрөгөөр илүү тооцоолж, үлдэх өртөггүй болгосон байна. Үүнд:

Энэ нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт 17-ын дагуу үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилж үнэн зөв тооцоолох” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС-17-ын дагуу үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилж үнэн зөв тооцоолох зөвлөмж хүргүүлсэн.

1.9.2 Цалингийн дансны талаар

Тайлант жилийн 1-12 сарын цалингийн зардлыг аудитлахад:

- Байгууллага тухайн сарын цалинг тухайн сарынхаа эхэнд тогтмол 1 удаа бүтэн олгосон байна.
- Сар бүрийн эхэнд ажиллавал зохих хоногоор цалинг тооцоолж, олгосон боловч сарын эцэст ажлын цагийн гүйцэтгэлээрх зөрүүг тооцоолоогүй байна.
- 12 дугаар сард зарим ажилтанд нэг өдрийн цалин илүү олгосон боловч үүнтэй холбоотой цагийн бүртгэл, тушаал шийдвэр байхгүй байна.
- Цалингийн бодолт хийсэн ажилласан цагийн бүртгэлийг тушаал шийдвэр, жижүүрийн цагийн бүртгэл, ажиллавал зохих хоног, чөлөөний хуудастай тулган шалгахад ажилласан хоног илүү, дутуу зөрүүтэй ажлын цагийн нэгтгэлийг алдаатай тооцоолсон байна.

Дээр дурдсан алдаанаас шалтгаалж, тайлант жилд нийт цалингийн зардал 24,331.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын зардал 2,647.6 мянган төгрөгөөр илүү тооцогдсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих. 16.5.7 байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах..., 26 дугаар зүйлийн 26.2.Төсвийн бүртгэлийг тохируулсан аккрузл сууриар бүртгэж, тайлагнана.” гэсэн заалтууд, Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1. Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно. 49.6.Цагаар ажилласан ажилтны цалин хөлсийг гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажилласан цагаар нь тооцож тухай бүр олгоно” гэсэн заалт, Хүүхдийн төв номын сангийн хөдөлмөрийн дотоод журмын 9.5 “Ажилтан нь ажлын цагт багтах цагаар хариуцсан ажлын шаардлагаар өөр байгууллагад /гадуур/ ажиллах үед удирдлагад мэдэгдэж, гадагш ажлаар явах тухайгаа бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

- Ажилтны цалин хөлсийг сард хоёр ба түүнээс дээш удаа, тогтоосон өдөр олгох, цалингийн зардлыг зөв тооцоолж, тухайн сарын зардлаар хүлээн зөвшөөрөх;
- Жижүүрийн хөтөлсөн цагийн бүртгэлд хяналт тавьж, ажилчдын ажилласан цагийн нэгтгэл гаргаж баталгаажуулах;
- Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхдийн төв номын сангийн хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох дүрэм журмын дагуу цалингийн зардлыг тооцоолох;

- Ажиллавал зохих хоногоосоо илүү ажилласан үед Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу нэмэгдэл хөлсийг олгох тухай зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

1.9.3 Ээлжийн амралтын олговрын талаар

Ээлжийн амралтын олговрыг тооцоолохдоо дундаж цалинд хоол унааны олговрыг оруулж тооцсон, нэг өдрийн дундаж цалинг 21.2-т хувааж тооцоолсон байна.

Дээрх алдаанаас шалтгаалан ээлжийн амралтын олговор 2,035.5 мянган төгрөгөөр илүү олгогдсон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 55.2. "Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно" гэсэн заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаал Дундаж цалин хөлс тодорхойлох журмын 4 дүгээр зүйлийн хэсэгт: "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлтийг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтыг тооцоолох арга, аргачлалыг тодорхой болгох, 2005 оны 55 дугаар тушаал Дундаж цалин хөлс тодорхойлох журмын дагуу хоол, унааны мөнгийг ээлжийн амралтын бодогдох цалингаас хасч тооцоолох зөвлөмж хүргүүлсэн.

1.9.4 Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн талаар

Тус байгууллагын харуул М.Түмэнбаярт хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн ажил олгогчоос олгох 81.3 мянган төгрөгийг 5 дугаар сарын олговол зохих цалин дээр нэмж, холбогдох татвар, нийгмийн даатгалын шимтгэл 15.4 мянган төгрөгийг суутгаж авсанаас тэтгэмж дутуу олгогдож нийгмийн даатгалын зардал илүү үүссэн байна. Үүнд:

Энэ нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаал Дундаж цалин хөлс тодорхойлох журмын 4 дүгээр зүйлийн хэсэгт: Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2005 оны 55 дугаар тушаал Дундаж цалин хөлс тодорхойлох журмын дагуу ажилтанд олгож байгаа бүх төрлийн тэтгэмжүүдийг цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй гэсний дагуу зөвлөмж хүргүүлсэн.

1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хүүхдийн номын ордон нь дараах хөрөнгүүдийг актлах талаар БСШУСЯ болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүсэлт илгээсэн байна. БСШУСЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газраас актлах зөвшөөрөл ирсэн ч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хариу ирээгүй байгаа тул 2017 оны тайлант жилд данснаас хасалт хийгдээгүй байна. Үүнд:

- ❖ БСШУСЯ-ны сайдын тушаалаар 2009 оноос эхлэн гадаад номын фондод тооллого үзлэг хийн Орос, Англи хэл дээрхи 21,593 ширхэг 129,522.28 мянган төгрөгийн номыг дахин үнэлгээ хийж үндсэн хөрөнгийн дансанд тусгах зөвшөөрөл мөн 10,178 ширхэг 40,116.02 мянган төгрөгийн ном, гадаад хэл дээрхи 17 ширхэг 145.8 мянган төгрөгийн CD, ашиглалтын хугацаа дууссан 20 нэр төрлийн 3,967.4 мянган төгрөгийн тогтмол хэвлэл, 19 ширхэг 79.86 мянган төгрөгийн задгай тогтмол хэвлэл зэрэг уншигчийн шаардлага хангахгүй уншлагад гардаггүй, хуучирсан, сэлбэн засварлах боломжгүй тул актлах;
- ❖ 2017 оны тооллогоор 20 нэрийн 33 ширхэг 16,861.05 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 19 нэрийн 63 ширхэг 4,127.68 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийт 21,988.73 мянган төгрөгийн хөрөнгө эвдэрч хэмхэрсэн, сэлбэн засварлах боломжгүй сэлбэг хэрэгсэл олдохгүй мөн ашиглалтын хугацаа дууссан тул актлах.

1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар:

- ❖ Цалингийн тооцоолол, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг холбогдох стандарт, хууль журмын дагуу хийгдсэн эсэхийг давтан тооцоолох.
- ❖ Дараагийн тайлант жилд үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тестлэх, үнэ цэнэ буурсан хөрөнгүүдийн өртгийг давтан тооцоолох асуудлыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

1.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Хүүхдийн төв номын сангийн төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 31,068.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 26,978.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 4,089.6 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

1.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Хүүхдийн төв номын сангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Аккурэйт Финанс Аудит” ХХК-ийн хийсэн аудитаар 1 зөвлөмж өгснөөс бүрэн хэрэгжүүлж, ажилласан байна.


1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Хүүхдийн төв номын сангийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 536,333.6 мянган төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 5,363.34 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

1.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Хүүхдийн төв номын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын



стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хүүхдийн төв номын сан нь санхүүгийн тайлант жилд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7, 26 дугаар зүйлийн 26.2 заалтууд, Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1, 49.6, Хүүхдийн төв номын сангийн хөдөлмөрийн дотоод журмын 9.5 заалтуудыг тус тус зөрчсөнөөс шалтгаалж цалин 24,331.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын зардал 2,647.6 мянган төгрөгөөр илүү тооцогдож, нийт 26,978.8 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Хүүхдийн төв номын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн Хязгаарлалттай санал дүгнэлт гаргалаа.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Хүүхдийн төв номын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

